



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, <http://www.frc.mn>

2023.04.11 № ЦМ-8/13 .

танай 2023.04.07 -ны № -т

“ВАНГИЙН ИВЭЭЛ” ХЗХ-НД

**Сонгуульт гишүүдийн өөрчлөлт
бүртгэсэн тухай**

Танай хоршооноос 2023 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр ирүүлсэн сонгуульт гишүүдийн өөрчлөлт бүртгүүлэх хүсэлтэд холбогдох нэмэлт баримт бичгийг Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Хорооны 2018 оны 245 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ын 8.2-т заасны дагуу хянаж, холбогдох бүртгэлд дараах өөрчлөлтийг бүртгэсэн болно. Үүнд:

| № | Хамаарал | Нэр | Тайлбар | |
|----|-----------------------|-----------|---------------|------------|
| 1 | Тэргүүлэгчдийн зөвлөл | Дарга | З.Энхбаатар | шилжүүлэн |
| 2 | | Гишүүн | З.Дамдинсүрэн | бүртгэлтэй |
| 3 | | Гишүүн | С.Оюунбилэг | бүртгэлтэй |
| 4 | | Гишүүн | Ч.Батчимэг | бүртгэлтэй |
| 5 | | Гишүүн | Д.Жавзмаа | шилжүүлэн |
| 6 | Хяналтын зөвлөл | Дарга | Н.Баянмөнх | шинээр |
| 7 | | Гишүүн | Г.Эрдэнэцэцэг | шинээр |
| 8 | | Гишүүн | Л.Цэнгэлмаа | шинээр |
| 9 | Зээлийн хороо | Дарга | Н.Батбаяр | бүртгэлтэй |
| 10 | | Гишүүн | Х.Алимаа | бүртгэлтэй |
| 11 | | Гишүүн | Н.Даариймаа | шилжүүлэн |
| 12 | Гүйцэтгэх захирал | Н.Батбаяр | бүртгэлтэй | |
| 13 | Нягтлан бодогч | Х.Алимаа | бүртгэлтэй | |

Тэргүүлэгчдийн зөвлөлийн даргын өөрчлөлтийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад ажлын 15 хоногийн дотор бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлнэ үү.

Ирүүлсэн баримт бичигтэй танилцахад “хурал даргалагч” болон хурлын нарийн бичгийн даргаар бүх гишүүдийн хурлын шийдвэрт гарын үсэг зуруулж байгаа нь дээрх хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т “Бүх гишүүдийн хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх ба шийдвэрт тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна”, 33 дугаар зүйлийн 33.1-д “Бүх гишүүдийн хурлыг тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга, түүний эзгүйд тэргүүлэгчдийн зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгч удирдана.”, 33.2-т “Бүх гишүүдийн хурлаас хурлын нарийн бичгийн дарга, тооллогын комиссыг сонгоно.” гэж тус тус

заасантай нийцэхгүй байгаа тул бүх гишүүдийн хурлыг зохион байгуулахдаа хуульд заасан дэгийг дагаж мөрдөхийг зөвлөж байна.

